



ШИНЭ ҮЕ СУРГУУЛЬ

ШУДАРГА БАЙДЛЫН ЖУРАМ

Шинэчилсэн: 2018 оны 3 сар
Дахин хянах: 2019 оны 6 сар

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Шинэ үе сургууль (цаашид “ШҮС” гэх) нь хүн амьдралдаа юу ч хийсэн түүндээ үнэнч шударга байхыг эрхэмлэдэг. Шударга байх зарчим нь бидний “хариуцлагатай иргэн төлөвшүүлэх” эрхэм зорилготой шууд холбоотой бөгөөд сурагч бүрт суралцах үйл явцаар олсон мэдлэг чадвараа харуулах жигд боломж олгохын үндэс суурь болдог.

Бид International Baccalaureate буюу Олон улсын бакалавратын байгууллагаас албан ёсоор тунхагласан доорхи ерөнхий зүй зарчмуудыг хүлээн зөвшөөрч дэмждэг. Үүнд:

“International Baccalaureate (IB) буюу Олон улсын бакалавратын хөтөлбөрүүд нь хүүхдүүдийг аливаа зүйлийн талаар асууж, шинэлэг, шүүмжлэлтэй байдлаар сэтгэн бодож, улмаар өөрийнхөө бодлыг аман болон илтгэх, үзүүлэн, загварчлал болон төрөл бүрийн бичгэн хэлбэрээр илэрхийлэх чадвартай болгодог. Гэтэл бид маш их мэдээлэл, бусдын санал бодлыг боловсруулах шаардлагатай үед амьдарч байна. Бид яаж хүүхдүүдийг өөртөө итгэлтэйгээр өөрийн суралцаж буй зүйлсийн талаар ярьж, бичиж, санаагаа яаж гаргаснаа боловсруулж, аль үзэлийг дагаж алианаас нь татгалзсанаа харах цогц чадвартай болгох вэ? Үүнд сургах арга нь шударга байх зарчим юм, өөрөөр хэлбэл, мэдлэг олж, түүнийгээ ойлгож, нээлттэй бодох явц юм”.

Шинэ үе сургууль сургалтын хөтөлбөртөө Олон улсын бакалавратын байгууллагын доорхи стандартуудыг нэвтрүүлэхийг зорьж байна. Үүнд:

- Олон улсын бакалаврат хөтөлбөрийн хэрэгцээнд нийцсэн шударга байдлын журам болосвруулж, хэрэгжүүлнэ (IB Standard B1, Practice 5e).
- Сургууль нь Олон улсын бакалаврат хөтөлбөрийг дэмжих дүрэм, журам, үйл явц болосвруулж, хэрэгжүүлнэ (IB Standard B1, Practice 5).
- Сургах, суралцах үйл явц нь шударга байдлын журмыг баримтлахад нийцсэн, дэмжсэн байна (IB Standard C3, Practice 4).

Шударга байх нь “зарчимч” байх гэсэн Олон улсын бакалавратын хөтөлбөрүүдийн хүүхдэд эзэмшүүлэхийг зорьдог сурагчийн 10 чадамжийн нэг хэсэг бөгөөд сурагчдыг аливаа үйлдэл хийхдээ “үнэнч шударга” байхыг шаарддаг. (*IB learner profile in review: Report and recommendation (April 2013), page 21*).

ШУДАРГА БУС БАЙДАЛ (ЖУРМЫН ЗӨРЧИЛ)

Олон улсын бакалавратын байгууллага нь шалгуулах, үнэлүүлэх явцын үеэр бусдаас ямар нэгэн байдлаар (санамсаргүйгээр болон санаатайгаар) давуу нөхцөл байдлыг шударга бусаар олж авахыг зөрчилд тооцдог. Олон улсын бакалавратын хөтөлбөрийн бусад горилгогч сурагчдад муугаар нөлөөлөх нь мөн зөрчилд тооцогдоно. Энэ зарчмыг зөрчсөн зөрчлүүдийн төрлүүдээс дурьдвал:



plagiarism (зохиолын, бүтээлийн хулгай) — бусдын санаа, ажил, бүтээлийг зохих ёсоор нь нийтэд мэдэгдэлгүйгээр (санаатайгаар болон санамсаргүйгээр) өөрийн мэт ойлголт өгөхүйц илэрхийлэх

collusion (хуйвалдах, нууцаар тохирох) — нэгнийхээ шударга бус үйлдлийг дэмжих, өөрөөр хэлбэл, өөрийн эсвэл өөр нэгнийхээ ажлыг хуулбарлаж үнэлүүлэхийг зөвшөөрөх

duplication of work (бүтээлийг хуулбарлах, олшруулах) — нэг ажлыг дахин хуулбарлаж үнэлгээний өөр өөр хэсгүүдэд олшруулан өгөх, жишээлбэл, нэг хичээлийн бүтээлийг нөгөө хичээлд өгч үнэлүүлэх

misconduct during an IB examination (шалгалтын үеэрх зөрчил) — (жишээлбэл, зөвшөөрөөгүй материал шалгалт руу авч орох, бусад шалгуулагчдад саад учруулах, бусадтай шалгалтын үеэр ярилцах)

unethical behaviour (ёс зүйгүй үйлдэл) — судалгаа хийх явцдаа оруулах ёсгүй, зүй бус зүйл оруулах, ёс зүйн журмыг зөрчих

бусад **шударга бусаар давуу байдал** өөрт үүсгэх, эсвэл бусад горилогч сурагчдад саад учруулснаар **муу үнэлгээ авахад нөлөөлөх** — (жишээлбэл, КАС-н мэдээллийг худал мэдүүлэх, бичгэн шалгалт өгсөн нэгнээс 24 цагийн дотор дижитал хэлбэрээр шалгалтын агуулгын талаар мэдээлэл авах эсвэл өгөх). (General regulations: Diploma Programme (Sep 2016), Article 20, page 12)

СУРАГЧДЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Сурагч нь багш, сургууль болон бусад гадны байгууллага руу явуулж байгаа бүх бүтээл нь өөрийн оригинал байхад хариуцлага хүлээнэ.

- Бусдын бичсэн бүтээл, зураг, диаграм зэргийг шууд ашигласан тохиолдолд иш татах аргуудыг ашиглан эшлэлд оруулна.

“MLA (Modern Language Association) буюу орчин үеийн хэлний холбооны хэв маягийг ашиглан судалгааны ажлуудад түлхүү ашигладаг эшлэлийн хэлбэрүүдийг ашиглана. Доорх линкээр дэлгэрэнгүй уншина уу.

Purdue Online Writing Lab (Purdue OWL) - <https://owl.english.purdue.edu>

- Бусдын санаа бодлыг ашигласан тохиолдолд тэр талаар нийтэд мэдэгдэж зохих ёсоор нь хүлээн зөвшөөрч, тэмдэглэл хэсэгт энэ талаар оруулна.
- Хүн бүрийн мэддэг мэдлэгийн талаар ямар нэгэн эшлэл хийх хэрэггүй.
- Сургууль багаар ажиллахыг дэмждэг боловч багаар ажиллаж хамтын бүтээл хийсэн тохиолдолд энэ талаар мэдэгдэж, ил тод байлгах хэрэгтэй.

Суралцах үед шударга бус байдал үүсгэх гол шалтгаан нь бодох, судлах, бичих үйл явцуудад хангалттай хугацаа зарцуулж чадаагүйгээс үүсдэг. Иймд, аливаа ажил, бүтээл хийхдээ эртнээс төлөвлөж, хангалттай цаг зарцуулах хэрэгтэй.



БАГШИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Бүх багш нар сурагчдын ажил бүтээлийг яг өөрийнх нь бүтээл мөн эсэхийг шалгаж, шударга байдлын журмыг мөрдөх хэрэгтэй. Мөн гадны эх сурвалж ашиглах тал дээр нь зөвлөгөө өгч, зохих судлагаа хийх, бичих чадварт сургах хэрэгтэй.

- Бусдын ажил бүтээлийг ашиглахдаа холбогдох стандартын дагуу хэрхэн иш татаж, ашигласан материалаа дурьдах ёстой талаар багш нар зөвлөгөө өгөх ёстой. Хэрэв багш энэ талаар хангалттай мэдлэггүй бол энэ талаар илүү мэдлэг туршлагатай багш, номын санч нартай хамтарч сурагчдад хэрэгтэй мэдээлэл өгөх хэрэгтэй.
- Багш нар сурагчдын ямар ч хэлбэрээр багшид хүлээлгэн өгсөн бүтээлийг маш анхааралтай хянах үүрэгтэй. Хэрэв сурагчдын бүтээлийн ихэнх хэсэг нь багшаас хол хийгддэг бол (жишээ нь дотоод үнэлгээний бие даалт эсвэл судалгааны эссе) багш сурагчидтай ойр ойрхон уулзах хэрэгтэй.
- Багш нар сурагчдын ажил бүтээл нь яг өөрийнх нь гэдгийг баталгаажуулахын тулд эцэг эхчүүдтэй хамтран ажиллах ёстой. Энэхүү шудалга байдлын журмыг баримтлахгүй тохиолдолд гарах боломжтой сөрөг үр дагаврыг багш удирдагч нарын хамт эцэг эхэд ойлгуулах хэрэгтэй.

СУРГУУЛИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

- Шударга байдлын журмыг баримтлахад сургуулийн захиргаа багш сурагчдад таатай орчин бүрдүүлж, үүрэг хариуцлагаа биелүүлэх нөхцөл бүрдүүлнэ.
- Сургууль багш нарт шударга байдлын зарчмын мөрдөхөд хэрэгцээтэй мэдлэг чадварыг дээшлүүлэх боломжоор хангана.
- Сургуулийн захиргаа багш нартай хамтран эцэг эхчүүдэд энэ талаар ойлголт өгч тэдний оролцоог нэмэгдүүлнэ.

ШУДАРГА БУС БАЙДАЛТАЙ АЖИЛЛАХ ЯВЦ

Ямар ч шударга бус байдалтай харьцахдаа бүх талуудыг харгалзан үзэж байж “өөрийн алдаанаас суралц” гэсэн үгийг баримтлан хамгийн үнэнч шударгаар шийдвэрлэнэ. Өөр өөр асуудлуудад нэг шийдэл байдаггүй тул тухайн нөхцөл байдалд тааруулан шийдвэрлэнэ.

Шударга бус байдалтэй харьцах хэд хэдэн ерөнхий алхамууд байдаг.

1. Хичээлийн багш тухайн зөрчлийг ангийн багшийн хамж мөрдөж эхэлнэ.
2. Багш сурагчид асуудлын талаар уулзалт хийнэ. Хэрэв сурагч ганцаараа ярихгүй эцэг эхийн хамт ярихыг хүсвэл эцэг эхийг нь дуудна.
3. Холбогдох тэнхимийн эрхлэгч, сургалтын менежер мэдэгдэнэ.
4. Ангийн багш ба сургалтын менежер эцэг эхэд мэдэгдэж хамтын уулзалт хийнэ.



5. Сурагчийн хувийн хэрэгт тухайн зөрчлийн талаар болон авсан арга хэмжээг тэмдэглэнэ.

6. Шударга байдлын талаар ангийн багшийн, сургалтын менежерийн, номын санчийн хичээлээс гадуурх сургалтанд сууна.

Шударга бус байдал эсвэл зөрчил гаргасан тохиолдолд сурагчид нэмэлт арга хэмжээ (жишээ нь тухайн даалгавар, улирал, жилийн дүнг бууруулах) авч болно. Хэрэв зөрчил дахин давтагдах тохиолдолд сахилга батын арга хэмжээ (хичээлээс чөлөөлөх эсвэл сургуулиас бүр чөлөөлөх санал гаргах) авч болно.

Багш нар зөрчил давтагдах тохиолдолд дараах үе шатаар арга хэмжээ авна.

Эхний удаа: Даалгаврын дүнг бууруулах, дахин шалгалтанд орох, бие даалт болон бүтээлээ дахиж нөхөж хийх, шударга байдлын талаар хичээлээс гадуурх хичээлд суух

Хоёр дахь удаа: Улирлын дүнг бууруулах, сахилга батын захиа гэрт нь хүргүүлэх, сурагч-багш-эцэг эхийн гурвалсан гэрээ байгуулах

Гурав дахь удаа: Жилийн эцсийн дүнг бууруулах, хичээлээс түр чөлөөлөх

Дөрөв дэх удаа: Сургуулиас бүр чөлөөлөх хүсэлт гаргах.

ЖУРМЫГ ХЯНАН ӨӨРЧЛӨХ ЯВЦ

Энэхүү журмыг хамгийн сүүлд хянан засварлаж өөрчилсөн өдрөөс хойшхи хоёр жил тутам дахин хянан өөрчилж байх болно. Хамгийн сүүлд энэхүү журмыг өөрчилсөн он, сар, өдөр уг журмын хуудас бүрийн баруун доод буланд тэмдэглээстэй байх ёстой.

Журамд оруулах аливаа өөрчлөлтийн талаархи санал санаачилгыг нийт багш нарын 70 хувиас доошгүй ирцтэй багш нарын хурлаар хэлэлцэн батлах ёстой. Багш нар тийнхүү журамд оруулахаар санал болгосон өөрчлөлтийг санал хураалтаар батална.

Тийнхүү баталсан засвар өөрчлөлтүүдийг сургуулийн захирал, сургалтын менежерүүд, хөтөлбөрийн зохицуулагч болон тэнхимүүдийн эрхлэгч нарын бүрэлдэхүүнтэй сургуулийн захиргаа дахин хянан үзэж, бусад журам болон дотоодын хууль тогтоомжид үл харшлахаар байвал батална.

Журамд хамгийн сүүлд оруулсан аливаа засвар өөрчлөлт нь сургуулийн захиргаанаас өөрөөр шийдвэрлээгүй бол дараачийн хичээлийн жилээс эхлэн хүчин төгөлдөр болно.



Article 21: Investigating cases of suspected academic misconduct

21.1 If questions arise about the authenticity of a candidate's work before submission for assessment, the situation must be resolved within the school. If possible academic misconduct (for example, plagiarism, collusion) is identified after a candidate's work has been submitted to the IB for assessment, the school's DP coordinator must inform the IB as soon as possible.

21.2 When a school, an examiner or the IB establishes evidence to suspect academic misconduct by a candidate, the school will be required to conduct an investigation and provide the IB with statements and other relevant documentation concerning the case. If a school fails to support the investigation into possible academic misconduct, no grade will be awarded to the candidate in the subject(s) concerned.

21.3 If the IB notifies a school that a candidate is suspected of academic misconduct and that the IB has the intention of initiating an investigation, at the discretion of the head of school it is permissible for the candidate to be withdrawn from the session or from the subject(s) in which academic misconduct may have occurred. However, at the discretion of the IB the investigation into the suspected academic misconduct by the candidate may still proceed and a decision be reached on whether to uphold or dismiss academic misconduct. If a candidate is withdrawn from a subject no mark for that subject may contribute to the award of a grade in a future examination session.

21.4 Candidates suspected of academic misconduct must be invited, through the school's DP coordinator, to present a written statement that addresses the suspicion of academic misconduct. If a candidate declines to present a statement, the investigation and decision on whether the candidate is in breach of regulations will still proceed.

21.5 The majority of cases of suspected academic misconduct will be presented to a sub-committee of the Final Award Committee. The sub-committee will normally comprise IB staff, school representatives, and chief/deputy chief examiners, but any group or combination of these persons may make decisions on cases subject to the approval of the Final Award Committee. The sub-committee will be chaired by the chair or vice-chair of the Final Award Committee, or a chief examiner nominated by the vice-chair.

21.6 Decisions of the sub-committee are made on behalf of and under the supervision of the Final Award Committee. After reviewing all statements and evidence collected during the investigation, the subcommittee will decide whether to dismiss the suspicion of academic misconduct, uphold it, or ask for further investigations to be made. If the sub-committee is unable to reach a decision, then the case will be referred to the Final Award Committee.

21.7 If the sub-committee decides that a case of academic misconduct has been established, a penalty will be applied in the subject(s) concerned. The penalty will, in the judgment of the sub-committee, be proportionate with the severity of the misconduct.

21.8 If no grade is issued for a subject that contributes to a candidate's IB Diploma, no IB Diploma will be awarded to the candidate. DP Course Results will be awarded for



other subjects in which no academic misconduct has occurred. Except in cases of serious or repeated misconduct, the candidate will be permitted to register for future examination sessions, which may include the session that follows six months later, if the relevant registration deadlines are met. In the case of an IB Diploma Candidate, if the session in which the academic misconduct has been established is the candidate's third examination session towards achieving the award of the IB Diploma, no further IB examination sessions will be permitted.

21.9 If the candidate has already been found in breach of regulations in any previous session, this will normally lead to disqualification from participation in any future examination session.

21.10 If there is substantive evidence, the IB is entitled to conduct an investigation into academic misconduct after a candidate's results have been issued. If academic misconduct is subsequently established by the Final Award Committee, or its sub-committee, the candidate's grade for the subject(s) concerned may be withdrawn from the candidate which will also result in the withdrawal of his or her IB Diploma where applicable.

General regulations: Diploma Programme (April, 2014), page 13